

МОНГОЛ ЗҮЙР ЦЭЦЭН ҮГЭН ДЭХ  
МЭДЭЭЛЛИЙГ ЭРХЭМЛЭХ ҮЗЭЛ

Л.Норовсүрэн\*, Адьяа\*\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

\*\* МУИС-ийн магистрант (Өвөр Монгол)

**Түлхүүр үг:** мэдээлэл, нийгэм, бичгийн соёл, эрхэмлэл, зүйр цэцэн үг, аман яруу найраг, ертөнц, хов жив, титэм, анхдагч хэрэгцээ, эрж хайх, хууль ёс

**Х**үн төрөлхтөн анх үүссэн цагаас өөр өөрсдийн оршин буй нөхцөл, байгаль цаг уур, аж амьдралын хэв маяг, соёл, зан заншилтайгаа уялдсан мэдээ зангийн харилцааг үүсгэн хэрэглэж, тэр нь үеэс үед улам боловсронгуй болж хөгжсөөр өнөөгийн мэдээллийн нийгэмд хүрэлцэн иржээ. Тэр дундаас монголчуудын мэдээ зангийн солилцоо нь мал аж ахуйг амьдралын гол болгосон нүүдлийн соёл иргэншилд зохицсон харилцаа байсаар ХХ зуунтай золгосон байна. Эртний монголчуудын мэдээ зангийн харилцааг сэтгүүл зүйн үүднээс дохио мэдээ, юм мэдээ, зураг мэдээ, тамга мэдээ, ам мэдээ, элч мэдээ хэмээн томъёолох саналыг энэ өгүүллийн зохиогч 2004 онд хэвлүүлсэн «Монголын нийтлэл»<sup>1</sup> хэмээх гурван боть нэг сэдэвт зохиолын тэргүүн дэвтэрт дэвшүүлсэн билээ.

Энэ удаад тэр тухай эс өгүүлэн монгол зүйр цэцэн үгэнд мэдээллийн

харилцааг хэрхэн эрхэмлэж, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, хэм хэмжээ, ёс зүйг яаж тодорхойлсон тухай өнгөц боловч авч үзэхийг хичээлээ. Хүн төрөлхтөн үг хэлтэй болсон нь мэдээлэл харилцааны түүхэнд гарсан том хувьсгал байв. Хэл яриа үүссэн нь хүний нийгмийн урт удаан хугацааны хөгжлийн үр дүн, анхны хүй нэгдлийн нөхцөлд хүмүүс хамт олноороо хөдөлмөрлөж, нийгмээрээ амьдардаг болсны улмаас хоорондоо харилцан санаа бодлоо солилцох зүй ёсны хэрэгцээгээр буй болсон зүйл юм. Тэр хэрэгцээ нь хүний тархинд үг хэлийг удирдах төвийг буй болгож, улмаар түүнд тохирсон үзүүр хязгаарын буюу өгүүлэх эрхтнийг аажмаар бий болгосноор үе гишүүт үг хэл үүссэн билээ.

Нүүдлийн соёл иргэншилтэй, тархай бутархай аж төрдөг монголчуудын хувьд ам мэдээллийг урт удаан хугацааны туршид эрхэмлэж иржээ. Тэгэхдээ тэрхүү мэдээллийг зөөгч, түгээгч нь хэн болохыг ч оновчтой тодорхойлчихсон байдаг. Манай ард түмэн «Аймгийн ховыг бадарчин зөөнө, айлын ховыг хүүхэд зөөнө» хэмээн хэлэлцдэг нь нийгэмд мэдээлэл түгээх гол хоёр суваг нь амьдралын эрхээр

аймаг хэц алгасан хоног төөрүүлж явдаг хэрмэл бадарчин, айл саахалтын хооронд өдөр тутмын явган мэдээ дамжуулж гүйдэг сониуч хүүхэд хоёр байсныг оновчтой тодорхойлсон хэрэг юм. Түүнчилэн монголчууд гэрт гадаа хаана ч тааралдсан "Сонин сайхан юу байна?" хэмээн хэлэлцдэг нь шинэ сонин мэдээлэл сонсох эн тэргүүний хэрэгцээг илэрхийлсэн мэндийн үг, яриа хөөрөө өрнүүлэх түлхүүр болдог байна. Тархай бутархай, аглаг зэлүүд аж төрөх нь мэдээллийн хэрэгцээг улам ч өсгөдөг байжээ. Тэд хүн ирвэл хэл занги дуулна гэж хүсэн хүлээдэг байв.

Монголчуудын ертөнцийг үзэх үзэл, аман яруу найргийн бичил хэлбэр болох зүйр цэцэн үгэнд мэдээллийг эрхэмлэх үзэл нэвт шингэсэн байдаг. Юуны өмнө мэдээлэл аль ч үед нийгмийн амьдралын эрэлт хэрэгцээ байж ирсэнийг илтгэсэн зүйр цэцэн үг олон байна. Монголчууд «Холын хүнээс үг сонс, ойрын хүнээс тус ав» гэгцгээдэг. Төв суурингаас алслагадхын хэрээр хүн ард улам найрсаг зочломтгой болдог нь зочин гийчнээс шинэ сонин мэдээ сонсох хэрэгцээ сонирхолтой нь холбоотой юм. Ийм хэрэгцээ сонирхол хуучин, шинэ уран зохиолд ч тусгалаа олсон байдаг. Д. Нацагдоржийн «Учиртай гурван толгой» дуурийн Нансалмаа «Хотоос ирлээ гэдэг чинь хоргойноос үнэтэй сонсогдож байна» хэмээн дуулж гардаг нь эр нөхрөө удаан хүлээсэн тэр бүсгүйд мэдээлэл авах хэрэгцээ анхдагч болсныг дүрсэлсэн хэрэг юм. Мөн «Эрт босвол нэгийг үзнэ, орой унтвал нэгийг сонсоно», «Мэдэж авбал эрдэм, мэнд явбал жаргал» гэдэг үг ч гэсэн амьдралд ашигтай чухал мэдээллийг байнга эрж хайж, түүнийг хэзээ ачаар оршин буй нийгмийнхээ

хууль ёс, дэг журмыг мөрдөж нийгэмтэйгээ мөр зэрэгцэн аж төрөхийг эрхэмлэсэн санаа мөн. Түүнчилэн «Цэцэнд хоёр чих цөөдөх, тэнэгт нэг ам олодох» гэдэг үгийн эхнийхэд шинэ сэргэг мэдээ сонсох, мэдлэг чадвараа байнга чамбайруулахыг эрхэмлэгч хүнд мэдээллийг аль болох олон сувгаар хүлээн авах, эрж хайх хэрэгцээ тулгарч байдаг бол, удаах хэсэгт тэнэг мулгуу хүн авшгүй үг, хов жив мэт хэнээр звийг эвдэж, гэрийг гуравдуулж явдгийг хэлсэн хэрэг байна. Бас «Жасын малаар баян болохгүй, жалгын үгээр цэцэн болохгүй», «Амсар муутай аяганд цай бүү хий, ам султай хүнд үг бүү хэл», «Ёс дагуулж үг хэл, үе дагуулж мах эвд» гэсэн үгс ч бий. Эдгээр нь аливаа мэдээлэл нийтэд хамаатай байх, хүнлэг, ёс жуудагтай байх шаардлагыг сануулж байна.

**М**онголчууд мэдээллийн үнэн бодитой байх зарчмыг эрхэмлэсэн зүйр цэцэн үгийг олон тоогоор зохион сургамжилж иржээ. Ийм үгийн титэм болгож «Нүд үнэнч, үг худалч» гэдэг үгийг эш татъя. Энэ нь аливаа мэдээ зангийн үнэн бодитойг гагцхүү нүдээр үзэж, биеэр оролцож байж л нотолдгийг хэлсэн хэрэг юм. Ялангуяа «чөлөөт» нэрийн дор дур зоргоороо аашлах болсон өнөө үед аливаа мэдээ, мэдээллийн үнэн магадтайд итгэх итгэл эрс суларсан нь нууц биш. Ганц энэ ч биш «Мянга сонссоноос нэг үзсэн нь дээр», «Хүний хар нүдэнд итгэхээр өөрийн шар нүдээр хар», «Дуулсан нь чихэнд, үзсэн нь нүдэнд» гэхчлэн сургадаг нь зөвхөн нүдээр үзэж, биеэр оролцсон үйл явдлыг л мэдээлэх зарчмыг номлосон үг юм. Хэрэв ам дамжсан дамтай үгэнд итгэж буюу санаатайгаар буруу ташаа мэдээлэл тараавал ямар эмгэнэлт байдалд хүрч болохыг «Үнэг үсэндээ,

хүн үгэндээ», «Дааганаас унаж үхдэггүй, даравгараас унаж үхдэг», «Хэлэхийн урьд болгоомж, хийхийн урьд хичээмж», «Харь газар үгээ бэхэл, халуун зуур эвээ хичээ», «Амаар олсныг амталж болдоггүй, үгээр үхүүлснийг өвчиж болдоггүй», «Зажлалгүй залгих ходоодонд муу, бодолгүй ярих үйлсэд муу» гэх мэтээр сэрэмжлүүлсэн байдаг. Эдгээр үгс нь мэдээллийг хав дараад дуулсан ч дуулаагүй юм шиг бай, дутагдал доголлын хажуугаар амаа үдүүлсэн мэт өнгөрөөд яв гэсэн үг огтхон ч биш, гагцхүү шалгаж нягталж байж нотлогдож батлагдсан мэдээлэл тараа гэсэн санаа юм.

Монголчууд үнэн бодитой мэдээлэл олж авахын тулд найдвартай эх сурвалжид тулгуурлаж, туйлын болгоомжтой хандахыг зүйр цэцэн үгээр дамжуулан сургамжилж иржээ. Юуны өмнө «Олон удаа бод, нэг удаа хэл» гэдэг үгийг онцолъё. «Долоо хэмжиж, нэг огтол» гэдэгтэй төстэй сонсогдох энэ үгэнд аливаа мэдээллийг түгээж тараахын өмнө хэд хэдэн эх сурвалжийн мэдээг харьцуулж, нэгийг нөгөөгөөр нь шалгах замаар үнэнд хүрэх зарчмыг номлосон байна. Мөн эх сурвалжаа оновчтой сонгохыг сануулж, эрх мэдэл бүхий хүнээс нэг талын мэдээлэл авахаас сэрэмжлүүлж, хэрэг явдлын үүсэл, өрнөл, үр дагавар, үр нөлөөг язгуураас нь мэдэх жирийн иргэдийн мэдээлэлтэй харьцуулж, тулгаж үзэх сэтгүүл зүйн зарчмыг ч монголчууд зүйр цэцэн үгэндээ олонтаа тусгасан байдаг.

«Хаанаасаа хаалгач нь, хатнаасаа аягач нь» гэдэг үг бол жирийн хүний үг жийрэггүй үнэн байдаг, тийм хүмүүсийг эх сурвалжаа болгогдсон нэг янзын сануулга юм. Энэ санааг бас «Доод хүнээс үг, доголон мориноос тоос» гэж шуудхан хэлсэн байна. Манай нэрт сэтгүүлч Н. Иштавхай агсан аливаа үйлдвэр, албан газрын ажлыг сурвалжлахдаа эхлээд албан газрын сахиул, үүдний жижүүр, жирийн

«

*Эх сурвалжаа оновчтой сонгохыг сануулж, эрх мэдэл бүхий хүнээс нэг талын мэдээлэл авахаас сэрэмжлүүлж, хэрэг явдлын үүсэл, өрнөл, үр дагавар, үр нөлөөг язгуураас нь мэдэх жирийн иргэдийн мэдээлэлтэй харьцуулж, тулгаж үзэх сэтгүүл зүйн зарчмыг ч монголчууд зүйр цэцэн үгэндээ олонтаа тусгасан байдаг*

»

ажилчинтай хуучилж, байгууллагын ажил, удирдлагын арга барилын талаар мэдээлэл авсны дараа эрх мэдэл бүхий хүмүүстэй уулздаг байсан гэхчилэн хашир туршлагатай сэтгүүлчдийн олон жишээг дурдаж болно.

Орчин үеийн сэтгүүл зүйн практикт нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх шаардлага тулгамдсан зорилтын нэг болж байгаа билээ. Өнгөрсөн зууны дөч, тавиад онд Америкт ажиглагдаж эхэлсэн "ардчиллын зэврэлт"-тэй холбогдон гарч ирсэн нийгмийн хариуцлагын онолын үндсэн агуулга нь сэтгүүл зүй улс төр, нийгмийн амьдралд хариуцлагатай байхыг шаарддаг шигээ өөрсдөө бас хариуцлагатай байж, хэлсэн үг, бичсэн зүйлийнхээ үнэн магадтайг нийгмийн өмнө хариуцдаг байх ёстой. Өөрөөр хэлбэл хийгүй ажиллах ёстой гэсэн санаа юм. Онолын хувьд томъёолоогүй ч гэсэн аливаа мэдээ мэдээлэл үнэн бодитой, хариуцлагатай байх тухайд зүйр цэцэн үгэнд туссан зүйл олон байна. «Хэлсэн үгэндээ эзэн болж, идсэн хоолондоо

сав болох», «Ам алдвал барьж болдоггүй, агт алдвал олж болдог», «Махны шарх эдгэдэг, үгийн шарх эдгэдэггүй» гэх мэтээр хэлэлцдэг нь мэдээлэл түгээгч хүний нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг хэлсэн хэрэг юм. Буруу ташаа мэдээлэл нэгэнт тарсан л бол түүнийг залруулахад нэн бэрх гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Тэр тусмаа мэдээллийн суваг олширч, хурд нэмэгдсэн орчин цагт энэ үгийн үнэ цэн улам ч есч байна.

Монголчуудын зүйр цэцэн үгэнд мэдээлэл харилцааны мөн чанар, зорилго зориулалт, нийгмийн хариуцлага, ёс зүй зэрэг орчин цагийн онолын томъёоллуудыг бүрэн багтааж, цэнэгшсэн цэгцтэй үгээр тодорхойлон хэлсэн байдаг нь нэн сонин төдийгүй манай ард түмний олон үеийн туршид хуримтлуулсан амьдралын туршлага, цэцэн мэргэн ухааны охь дээж болж өнөө үед өвлөгдсөн байна.

**М**эдээлэлд шударга ёсыг эрхэмлэж, голч байр сууринаас хандан чин үнэнийг өгүүлэх зарчмыг ч зүйр цэцэн үгэнд олонтаа тусгасан байдаг. Түүгээр ч үл барам ихэс дээдэс, эрхтэн дархтнуудын хувьд сэтгүүл зүй ямагт сөрөг хүчин байж, тэдний буруу үйлдлийг илчилж байх орчин үеийн сэтгүүл зүйн зарчим ч зүйр цэцэн үгэнд ямар нэг хэмжээгээр агуулагдаж байна. Үүний тодорхой жишээ нь «Бялдууч хүн дийлсэн талд нь, балчир хүүхэд инээсэн талд нь», «Бааран хүнд нохой амраг, бялдууч хүнд ноён амраг», «Туйлбаргүй хүн няцах нь амархан, тугалган жад шантрах нь амархан», «Сайрхуугийн үг шалбааг, даруугийн үг далай» хэмээн цэцлэн хэлэлцдэг явдал мөн. Эрх мэдэлтэн, бэл бэнчинтэнд тал засаж, тэдний дутагдлыг нуун дарагдуулж, байтлаа бүр намтар түүхийг нь хөлсөөр

бичиж, захиалгаар магтдаг болсон өнөө үед дээр дурдсан ухаант ардын цэцэн мэргэн үгс улам ч үнэд орж байгаа билээ.

Э. М. Канив нэгэнтээ «Хэл бол цахиур, үг бол салхи, нийлээд түймэр асаана»<sup>2</sup> гэж үг яриа, мэдээ мэдээллийн хүч, нөлөөлөх чадварыг ончтой тодорхойлсон байдаг. Монгол зүйр цэцэн үгэнд мэдээллийг эрхэмлэх, мэдээлэх арга ухаан, баримтлах зарчмыг заан сургахын зэрэгцээ мэдээ, мэдээллээр дамжуулан нийгмийн өө гажгийг илчлэн шүүмжилж, засаж залруулах санаа арвин байдгаараа орчин үеийн сэтгүүл зүйн үнэт уламжлалтай нягт холбогддог юм.

«Сайн эм гашуун ч өвчинд тустай, шударга үг хатуу ч явдалд тустай» гэх мэтээр шүүмжлэлийн зорилго, нийгмийн үр нөлөөг илэрхийлсэн байдаг бол, «Үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй», «Магтлаа гэж бүү сагсуур, мууллаа гэж бүү өширх», «Муу морь өдрийн аяыг даахгүй, мунхаг хүн үгийн гашууныг даахгүй» гэж илчлэн шүүмжлэх мэдээлэл олонх тохиолдолд эсэргүүцэлтэй тулгарч байдгийг хэлсэн нь цаад утгаараа энэ төрлийн мэдээлэлд туйлын болгоомжтой хандаж, баталгаатай баримтад тулгуурлаж байхын чухлыг сануулсан хэрэг юм.

Ардын уран зохиолч Т. Галсан «Бэлгэ үг бол ерөөлийн гол охь, цэцэг цэцэгнээс түүсэн зөгийн бал шиг, сэцэн оюуны гэгээн тарни билээ»<sup>3</sup> гэсэн байдаг. Түүнтэй адилхан зүйр цэцэн үг бол сургаал номлолын гол охь, хүн судрын цуглуулсан үнэт эрдэнэ билээ. Ардын зүйр цэцэн үгэнд байгаа бас нэг чухал сургамж бол аливаа мэдээлэл товч тодорхой байх тусмаа хүнд хүрч нөлөөлөх чадвартай болдгийг онцолдог явдал мөн. Ялангуяа «Монгол хэл

соёлыг маань мохоон ядууруулж болзошгүй нэгэн гамшиг нүүрлээд байгааг хэн бүхэн улиглан ярьдаг боловч, биетэй бодитой хувь нэмэр оруулсан хүн тийм олон биш»<sup>4</sup> байгаа өнөөгийн нөхцөлд үгийг үнэлж, хэмнэж, онож хэрэглэх явдал чухал болж байгаа юм. Энэ шаардлагыг зүйр цэцэн үгэнд тусгасны жишээнд «Мянга хэлсэн ч занги нэг», «Их мэд, бага ярь», «Дээлийн таарсан нь, үгийн цөөн нь дээр» гэх мэтийг нэрлэж болно.

Эцэст нь тэмдэглэхэд ард түмний цэцэн мэргэн ухааны охь дээж болж, өө сэвээ барж шалгаран шилэгдсэн аман яруу найргийн бичил хэлбэр болох зүйр цэцэн үгэнд орчин цагийн сэтгүүл зүйн мэдээлэлд тавигддаг шаардлага, шалгуурыг бараг төлөв тодорхойлж, цэцлэн хэлсэн байдаг нь цаашид гүнзгийрүүлэн судлууштай чухал сэдэв мөн.

#### Ишлэл

<sup>1</sup> *Норовсүрэн Л.* 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 10 дахь тал.

<sup>2</sup> *Намжав Д.* 2007. Амжилт дагуулах үгс. УБ., 7 дахь тал.  
<sup>3</sup> *Галсан Т.* 2009. Бэлгэ үг. Дэд боть. УБ., 3 дахь тал.  
<sup>4</sup> *Дулам С.* 2009. «Бэлгэ үгсийн билиг оршихуй». Бэлгэ үг. Дэд боть. УБ., 3 дахь тал.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Норовсүрэн Л.* 2000. Монголын сэтгүүл зүйн түүрэн тойм. Тэргүүн дэвтэр. УБ.
2. *Норовсүрэн Л.* 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.
3. *Намжав Д.* 2007. Амжилт дагуулах үгс. УБ.
4. *Галсан Т.* 2009. Бэлгэ үг. Дэд боть. УБ.
5. *Ариунзаяа Н.* 2014. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж. УБ.
6. *Ариунзаяа Н.* 2009. Соён гэгээрүүлэгч "Шинэ толь". УБ.

#### Summary

This article analyzed preferable concepts of information of the Mongolian proverbs based on specific examples. It highlighted how proverb identified main principles, such as roles, life concepts, ethics, and exchange of ideas toward to the informative society.